

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хонгор сумын ОНХС-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/68/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: О.Мягмарсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.14 № 85
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.АТАРХИШИГ
ТАНАА



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛВАНГУУРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009070071

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	243,041,993.00	40,345,292.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
	Нийт хөрөнгийн дүн	243,041,993.00	40,345,292.00
	Нийт өр төлбөрийн дүн	243,041,993.00	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	40,345,292.00
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	243,041,993.00	40,345,292.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	904,017,775.00	1,065,393,056.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	904,017,775.00	1,025,047,764.00
	Үйл ажиллагааны үр дүн	-	40,345,292.00
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	40,345,292.00
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	-	40,345,292.00
	Эцсийн үлдэгдэл	-	40,345,292.00
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	904,017,775.00	1,065,393,056.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
	Үйл ажиллагааны ЦМГ	904,017,775.00	1,065,393,056.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	904,017,775.00	1,025,047,764.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	40,345,292.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,345,292.00
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
		1,499,916,700.00	1,025,047,764.00
	Урсгал зардал	1,680,343,000.00	1,637,142,301.69
	Хөрөнгийн зардал	1,499,916,700.00	1,025,047,764.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,499,916,700.00	1,065,393,056.00
	Улсын төсвөөс санхүүжих	1,499,916,700.00	1,065,393,056.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын ОНХС нь Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийн аюулгүй амьдрах орчныг сайжруулах, эрүүл идэвхтэй амьдралыг дэмжих, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, соёл урлаг, боловсролын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, авто замыг засварлан шинэчлэх, хатуу хучилттай авто зам шинээр барих, тохилог орчин эко хорооллыг бий болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлдэг байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Хонгор сумын ОНХС-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 152,338.8 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлснээс 7,934.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 144,404.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

7.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны дүнг аудитын хийсэн дүнгээс 681.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг аудитын явцад залруулсан болно.

7.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

7.3 Албан шаардлага

Тайлант онд Шилэн дансны нэгдсэн системд байршуулах 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 654,709.9 мянган төгрөгийн 17 гүйлгээ, 23 нэр төрлийн 1,100,398.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий ерөнхий мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.3-д *“тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгаруулаагүй хуулийн үндэслэл, шалтгаан”*- ийг 7 хоногийн дотор, 6.4.4-д *“таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”*-ийг 7 хоногийн дотор мэдээлэх гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	2,436.2	1	681.1	-	-	1	1,755.1	-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	2	2,436.2	1	681.1	-	-	1	1,755.1	-	-